

МОНГОЛЧУУД ЕВРАЗИЙН ГЕОПОЛИТИКТОЙ ХОЛБОГДОХ НЬ

Онц бөгөөд Бүрэн
эрхт элчин **Х.Олзвой**

Геополитикийн асуудал сүүлийн 10-аад жилд улам анхаарал татаж ертөнцчилөл, дэлхийн бодлогын шинэ үетэй хамсан өргөн утгаар, улс орон бүрийн хувьд шинэ сэргэгээр тавигдах болов. XIX зууны сүүл, XX зууны туршид их гүрнүүд, томоохон орнуудын геополитикийн тухай үзэл баримтлал газар авч тэр нь газрын детерминизмээс аваад фашизм, шовинист үзэлтэй холилдож, том гүрнүүдийн бодлого, стратегийг тодорхойлж, тэдний зүгээс олон улсын харилцааны байдал, төрх, төлвийг дүгнэн шинжлэх зэвсэг нь болж ирсэн байна. Манайх мэтийн олон жижиг, дунд оронд геополитикийн шинжлэх ухаан онцгойрон хөгжөөгүй өнөөг хүрчээ. Тэр тусмаа манай орны эрдэмтэн, мэргэжилтнүүд мөнөөх пролетарийн интернационализмын зарчимд үндэсний эрх ашгаа захируулж геополитик гэх мэт шинжлэх ухааныг "үнэн байдлыг гуйвуулж байдаг бөгөөд иймд шинжлэх ухааны эсрэг гүн чиглэсэн үзэл бодол"¹ гэсэн бүхнийг заагч ах нарын"- хаа зааварт баригдаж ирсэн билээ.

Гэтэл 1990-ээд оны эхээр хүйтэн дайнд далайн хүч ялж ЗХУ задарч, Берлиний хана нурж, глобалчлал буюу ертөнцчилөл гэсэн бүхнийг хамаарагч үзэл санааны дор атлантзмын буюу өрнөдийн үнэ цэнт үзэл санаа (ардчилал, зах зээл г.м.) дэлхийд тархан өнөөдөр "нэг дэлхий"-н үзэл баримтлал 1648 оноос мөрдөгдсөн Вестифалийн системийн үндсэн тулгууруудыг ганхуулж мэдээллийн хувьсгал, зэвсэг техникийн дэвшил улсын бүрэн эрхийг ч сулруулж аэрократ, тэр бүү хэл эфирокрытыг хамарсан Lebensraum үүсэх төлөв байдал нэгэнт бий боллоо. Олон улсын харилцаа шинэ дэг журам руу шилжиж олонхи судлаачдын үзэж буйгаар хоёр туйлт системээс олон туйлт руу шилжиж орлоо. Харин миний бодлоор атлантзм хүчээ авч, өрнөдийн соёл иргэншил ноёрхохоор заналхийлсэн, АНУ тэргүүтэй нэг туйлт ертөнц рүү хүн төрөлхтөн чирэгдэн орж байж болзошгүй болоод байна. Яг энэ үед Евразийн үзэл санаанд тулгуурлан ОХУ-ыг хүчирхэгжүүлэхийг зорьсон эрдэмтэн, судлаачид Орост олноор гарч бүтээл, туурвилаа ар араас нь гаргах боллоо. Евразийн энэ шинэ (яагаад гэвэл 1920-иод онд Н.И.Савицкий, Трубецкий, 1960-аад оноос Л.Н.Гумилев болон бусад их эрдэмтэд Евразийн геополитикийг үндэслэн хөгжүүлсэн билээ) хөдөлгөөнд В.Жириновский, Г.Зюганов зэрэг намын дарга нар, А.Митрофанов гэх мэт төрийн түшээд, А.Дугин, Э.Поздняков, Н.Нартов, Ю.Тихонов, К.Сорокин, К.Гаджиев гэх мэт эрдэмтэн багш нар

¹ Л.А. Моджорян, "Геополитика на службе военных авантур", М.1974, с.5

² Н.А. Нартов. "Геополитика", М., 1999, с.102

³ Мөн тэнд

идэвхийлэн орж бүтээл туурвил, сурах бичгээ гарган шуурхай оролцох болов. Украин мэт хуучин ЗХУ-аас тасран туурга тусгаарлагч улсуудад ч геополитикийн ном зохиол гарсаар байна.

Нөгөө талаас АНУ-ын геополитикчид 1960-1970 -аад оноос онол, практикийн хувьд идэвхжиж эхэлсэн бөгөөд түүнийг Х.Киссенжер, З.Бжезинский, С.Хатингтон, И.Фукуяма гэх мэт олон нэрт эрдэмтэн, төрийн зүтгэлтнүүд тэргүүлэн оролцож байна. Тэд ОХУ-ыг улам сулруулах, анакондын бодлогыг хэрэгжүүлэхийг уриалан, "онол"-ын талаар үндэслэхийг зорьж байна. АНУ-ын засаг захиргааны гадаад бодлогын үйл ажиллагаа үүнд чиглэсээр ирсэн билээ.

Еврази нь Оросын өвөрмөц байдлыг цохон тэмдэглэж Орос орон шинэчлэгдэх, глобалчлал (ертөнцчилөл)-д орохдоо баруунжих (Westernization) хэрэггүй, ер нь өрнөдийг эсэргүүцсэн газар зүй-геополитикийн орон зай бол Евразийн heartland (зүрхэн газар)-ЗХУ юм гэх санаанд үндэслэн хөгжиж байна.

Евразийн тухай ярихдаа Монголын тухай эрхгүй дурсаж түүний түүхэн үүрэг, цаашдын төлвийг нэр дурдсан эрдэмтэн, мэргэд дурдсан, онцлон тэмдэглэсэн байх юм. Ер нь Еврази хэмээх геополитикийн онцгой тив-орон зайг бүрдүүлэх, Оросын өвөрмөц байдал гэдгийг бий болгоход монголчууд онцгой нөлөө үзүүлсэн түүхэн гавьяатай юм. Юуны өмнө тэмдэглэхэд, П.Н.Савицкий (1895-1968) гэх мэт Оросын сонгодог геополитикчид бүтээл туурвилдаа Орос орны үндэс Киевийн Русь, дараахи Орос улсын үед тавигдаагүй гэдэг. Тухайлбал, Киевийн Орос, хожмын Оросын хооронд түүхэн залгамж холбоо байгаагүй гэж Н.С.Трубецкий гэх мэт евразичууд үзэж байсан² бөгөөд Оросын сонгодог геополитикч П.Н.Савицкийн бичсэнээр "Татарчлалгүй бол Орос байхгүй байхсан"³, өөрөөр хэлбэл, эртний Русь, Их талтай Алтан ордны үед холбогдсон нь энэ хоёр талын (ой ба тал хээр) цэрэг - улс төрийн холбоо байв. Энэ холбоо зөвхөн цэрэг, санхүүгийн хувьд ч биш бас геополитикийн хувьд Орост ашигтай байжээ. Монголчууд Оросыг эзэлснээр оросууд Евразийн үйл явдалд татагдан орсон бөгөөд үүгээрээ төрчлөлийн техникийг эзэмших, ер нь төрийн оюун санааг авахад асар их нөлөө үзүүлсэн байна. Мөн олон үндэстний улс төрийн үзэл санаа Киевийн Русийн төрчлөлийн ойлголтыг өөрчлөхөд хүргэжээ. Түүхийн явцад төрчлөлийн тухай монгол ухааныг оросчлох, үнэн алдартны шашинд ойртуулах үйл явц явагдсан гэдэг. Монголчуудад эзлэгдсэний дараа Русь Монголын их гүрний геополитикийн хүрээнд бүрэн орж улмаар хожим нь П.Савицкий, түүний шавь Л.Н.Гумилев зэрэг алдарт геополитикч нар Монголын өв, уламжлалын тухай дуугарахад хүрсэн байна.

"Орос бол их хаадын өв залгамжилагч, Чингис, Төмөрийн хэргийг үргэлжлүүлэгч, Азийг нэгтгэгч"⁴ гэж Евразичууд үзэж байлаа. Дараа дараачийн үйл явдал юуг харуулсан бэ гэвэл, нэгдсэн улсын тухай Монголын санааг Оросууд ашиглан нутгийг минь ч нөлөөндөө авах,

⁴ Л.Н.Гумилев. Древняя Русь и Великая степь, М., 1989, гл. VI-IX, Ритмы Евразии, М., 1993, с. 521-529

Сибирь, Буриадад их суурьших замаар газрыг нь эзэмших, тэдний хэллэгээр "татарын газрыг цуглуулах" замд орсон билээ. Түүхэн геополитикийн нугачаа, бүдрээтэй байсан билээ.

Өнөөгийн Еврази агуулга, хэмжээ, орон зайгаа тэлж, эх газрын хүчний үндсэн нутаг, их гүрнүүдийн тэмцлийн heartland болсон байна. Энэ тухай ярихын өмнө бас нэг онцлон дурдууштай зүйл бол XIII, XIV зуунд Монголчууд яагаад хүчирхэгжин хэт их гүрний хэмжээнд хүрч Евразийн геополитикийн тивийг бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн бэ? гэсэн асуудлаар товч хэдэн санаа хэлэхэд:

1. Монгол бол Еврази ч гэж болох Азийн төвд байрласан эх газрын төв байрлал гэдэг бол хүчирхэг орнуудын хувьд геополитикийн нэн давуу тал гэж үздэг орон байсан;
2. Монгол морь нь цэрэг армийн хурдан хөдөлгөөнт чанарыг хангаж, техникийн давуу талыг Чингис, түүний залгамжлагчдад олгосон;
3. Төр, цэргийн зохион байгуулалт, дэг журам, сахилга бат, зорьсондоо хүрэх итгэл, хөх тэнгэртээ шүтэх үзэл өндөр байсан;
4. Төлөвлөсөн удирдлага буюу идеократын шинж тэмдэг туйлдаа хүрсэн;
5. Нутаг дэвсгэр, орон зайгаа тэлэх замаар их гүрэн болж сүр, хүчээр улсаа хамгаалах үзэл бодол нь төр, цэргийн дээд удирдлагад тэдний өсч хүмүүжсэн орчин, тэр үеийн төр улс, отог аймгийн оршин тогтнох бололцоо нөхцлөөс үүдэн бий болсон. Энэ нь Францын их геополитикч Видаль де ла Блашийн дэвшүүлсэн "поссибилизм"-ын онолын хүн бол "газар зүйн хүчин зүйл" бөгөөд орон зайг амилуулахад хүний санаачлага чухал гэсэн цөм хэсгээр тайлбарлагдана.

Монгол гүрэн геополитикийн нөлөөг улс, хэт их гүрэн байхаа больж уналтанд орсон зарим шалтгааныг толилуулахад:

1. Аливаа эзэнт гүрэн хүчээр орон зайгаа тэлж түрэмгийлэлд тулгуурласан эзэрхэг бодлого явуулбал эзэлсэн, нөлөөний хүрээнд байлгасан ард түмний уур хилэн эгдүүцлийг төрүүлж эцэстээ нуран унадгийг Их Британи болон бусад колоничлогч гүрнүүд, эзэн Чингисийн их аян дайн, эзлэх захирахын тэчъяал, хүний нутагт төвхнөсөн Хубилайн Юань гүрний түүх, Гитлерийн Германы Lebensraum - аа тэлэх бодлого, ЗСБНХУ-ын нөлөөгөө тэлэх, нэг үзэл суртлыг тулгах бодлого, жижиг улс, ард түмний эсэргүүцлийн сэтгэл зүйн тод онцлог харуулж байна.

2. Аливаа гүрэн эрчимт хүмүүсийн тооны олноор нэг үед мандан бадарч аминч хүмүүсийн нөлөөгөөр нөгөө үед бууран доройтож тэр нь 1200-1500 жилийн давтамжтай явагддаг тухай Л.Н.Гумилевийн "пассионарность" буюу эрчимт хөгжлийн онолоор Монгол гүрний бууралт, уналтыг бас тайлбарлаж болох юм.

3. Эх газрын идеократын систем ноёрхож, эрх мэдлийн төлөөх тэмцэлд аажмаар татагдан орохын хамт байлдан дагуулах бодлогодоо хэт автагдаж дотоодын аюулгүй байдалд анхаарал суларсан (2001.9.11-нээс өмнөх АНУ-д энэ хандлага ажиглагдлаа.) нь эзэнт гүрэн нурахад

бас нөлөөлсөн гэж болмоор. Чингис хаан үр хүүхэд, жанжин нартаа эзэлсэн газар нутгаа хуваахдаа хоорондын улс төр, эдийн засгийн хэлхээ холбоог сулруулсан нь нөлөөлсөн байх.

Энэ бүхний эцсийн дүнд Евразийн үндсийг тавьсан эзэнт гүрний гүйцэтгэх үүрэг, нөлөө, хүч суларч геополитикийн тэр их орон зайд их гүрнүүдийн жийрэг болсон зах хязгаар (периферия) улс болсон юм. Гэвч Монгол улс 1911 онд Богд хаант улсаа тунхаглаж, түүхч Л.Жамсраны тодорхойлсноор сэргэн мандалтын эхэн үедээ орсон билээ. Энэ бол Евразийн геополитикт гарсан анхны ч гэж болохоор удаан нойронд байсан өөрчлөлт, чичиргэлтийн нэг байсан юм. Монгол төр, улс сэргэн мандаж, олон улсын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болсон нь наанадаж доорхи хэдэн зүйлтэй холбоотой гэж боддог. Үүнд:

1. Нүүдлийн соёл иргэншлээ ямагт хадгалан үндсэнд нь ариун дагшин байлгасан;
2. Хүн улсын үеэс өнөөг хүртэл нутаг дэвсгэрээ төрийн зиндаанд хамгаалан Модун шаньюйн үгээр "Газар нутаг бол төр улсын оршин тогтнох үндэс мөн"⁵ гэсэн чиг шугамыг барьж ирсэн;
3. Монгол орон манжийн нөлөө, хүрээнд 220 жил болохдоо ч тэдний адил хятад ханз, күнзийн үзэл санааг аваагүй, өөрөөр хэлбэл соёл, хэлний колоничлол, нөлөөлөлд ороогүй;
4. Хэл, хил, мал сүрэг, амьдралын зуршил, заншлаа, шашин шүтлэгтэйгээ их гүрнүүдийн нөлөөн дор ч элдэв хувьсгал, намчлал, ардчиллын далбаан дор ч уураг тархи, бие сэтгэл, авдар савандаа хадгалан уламжлан үе залгамжлуулж ирсэн;
5. Урд, хойд гүрнүүдийнхээ даралт, дарамтыг ямагт дотроо эсэргүүцэн бололцоотой бүх аргаар сэргэн тэмцэж байсан, гуравдахь гүрэн, улсуудтай найрсан түншилж, хүчнүүдийг тэнцвэржүүлэхийг зорьж ирсэн зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой юм.

Хэлфорд Маркиндер 1904 онд Еврази - Heartland гэсэн "түүхийн тэнхлэг" -ийг тодорхойлохдоо Хятад, Зүүн өмнөд Ази, Энэтхэг гэх мэт орон зайд "дотоод хагас сард" оруулж байсан бол Збигнев Бржезинский 1997 онд бичсэн "Евразийн хувьд баримтлах геостратеги" гэдэг өгүүлэлдээ энэ геополитикийн тивийн эзлэх талбайг улам тэлж Хятад, Энэтхэгийг ч оролцуулан тооцож "Еврази нь дэлхийн хүн амын 75%, ННБ-ий 60 %, эрчим хүчний нөөц баялагын 75 хувийг эзэлдэг⁶ гэсэн байна. Тэрбээр "Евразид давамгайлагч аливаа гүрэн дэлхийн эдийн засгийн талаар хамгийн бүтээцтэй гурван бүсийн хоёрт, тухайлбал Баруун Европ, Зүүн Азид шийдвэрлэх нөлөө үзүүлэх болно" гэж бүсийн орон зайн ач холбогдлыг дурдсан байдаг. Тэгээд лав нэг үеэс илүү хугацаанд дэлхийн нэгдүгээр гүрний хувьд эзэлж буй АНУ-ын статусыг ямар нэг ганц орны зүгээс өрсөлдөн үгүйсгэж чадахгүй. АНУ-д цэрэг, эдийн засаг, технологи, соёлын талаар өрсөлдөх, уралдах гүрэн гарахгүй

⁵ Ж.Бор. Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал, УБ, 1988, х.38

⁶ Zbigniew Brzezinski. A Geostrategy for Asia. Foreign Affairs, September/ October 1997, p.50

гэж баталсан юм. Тэгэхээр Евразид хүчний тэнцвэр барих, хөгжлийн таатай гадаад орчинг бүрдүүлэхэд энд оршигч дунд, жижиг орнууд, ялангуяа далайд гарцгүй, цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн, хоёр том гүрний дунд хавчуулагдсан, ардчилал, зах зээлийн эдийн засагт тэмүүлэн Монгол орон АНУ, бусад гадны том гүрнүүдтэй харилцаа, харилцан ажиллагаагаа өргөтгөж нөмөр нөөлөгт нь түншлэх ойртох нь зүйн хэрэг буй заа. Тэгэхдээ хоёр хөрштэйгөө бүхэлдээ тэнцвэртэй харилцаж "айл хүний амь нэг, саахалт айлуудын санаа нэг" зарчмаар ажиллах нь XXI зууны Евразид бид өөрийн өнгө хэлбэртэй, өртөөлөх орон зайтай хоцрохын нэг үндэс гэдэг нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, байгалийн хоёр хөрштэй, байнгын өөрийн ашиг сонирхолтой, бахдам хэдэн том түнштэй байх нь манай гадаад бодлого, геополитикийн зөв чиглэл болох нь дамжиггүй. Энэ ялдамд тэмдэглэхэд, З.Бжезинский дээр дурдсан өгүүлэлд хавсаргасан "Томорсон Хятад" гэх зурагтаа манай улсыг тэрхүү Lebensraum - аа тэлэгч орны "шинэ" хилийн дотор оруулан зурсан нь аль хэдийн буцаагдсан Хонконг, Макао, одоо ээлж нь гэгдсэн Тайваний дараа нөгөөх Дэн Сяопиний М.Горбачевт 1984 онд дурдаж байсан "алдагдсан 1 сая 500 мянган хавтгай дөрвөлжин нутаг нь" биш байгаа даа, үүнийг нь АНУ-ын геополитикч зөвшөөрч байгаа юм биш байгаа гэсэн сэтгэл төрөх юм.

Гэвч гео-эдийн засгийн үүднээс үзвэл байдал өөрөөр төсөөлөгдөж байгаа юм. Сүүлийн жилүүдэд идэвхжсэн Зүүн Хойд Азийн (ЗХА) эдийн засгийн хамтын ажиллагааны төслүүдийн хүрээнд Монгол улс Европ - ЗХА-ийг холбосон төмөр зам, автозам, агаарын замын гүүр ч болж болох, Сибирь - Хятад - Солонгосын хойг - Хятад - Японыг холбох газрын тос, байгалийн хийн хоолойн дайран өнгөрөх дөт зам ч болох боломжтой байгаа тухай холбогдох эрдэмтэн, мэргэжилтэн нар шүүж ярилцаар байна. Мөн өнөөгийн гео эдийн засгийн чухал бүс болсон Каспи, Дундад Ази руу АНУ, Япон, БНСУ-ын компаниуд Монголыг дамжих түшиц газар болгох боломж, тэрбүүхэл, тодорхой төсөөлөл ч дэвшүүлэгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэ бүхэн нь Монгол улс Евразид өөрийн гэсэн үүргийг гүйцэтгэх бололцоо байгаа бөгөөд түүний стратегийн ач холбогдол буураагүйг харуулж байна.

Харин Евразид янз бүрийн соёл иргэншил айлсаж бие биеэ түрж, шашны томоохон урсгалууд идэвхжин зөрчилдөж, олон улсын терроризм болон бусад эрүүгийн гэмт хэрэг, үндсэрхэг үзэл, шашны туйлшрал дээр тулгуурлан өргөсч энэ бүхнийг их гүрнүүд өөр өөрийн ашиг сонирхол, геостратегийн зорилгодоо ашиглах гэсэн хандлага илт явагдаж байна. Энэ нөхцөлд ард түмнийхээ, хувь хүний аюулгүй байдлыг баттай хамгаалах, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд дурдсан эвсэлд үл нэгдэх, төвийг сахих бодлогоо тууштай баримтлах, олон улсын хямрал зөрчилд шамдан оролцмооргүй санагдана. Энэ өнцгөөс харвал Монголын агаарын зайг АНУ-ын цэргийн онгоцуудад ашиглуулах шийдвэр /амлалт/ манай нэгэнт тунхаглан зарласан бодлоготой нийцэх эсэхийг ч бодмоор. Тэгэхдээ геополитикийн үүднээс буюу эсвэл манай улсын эрх ашгийн үүднээс

үзвэл АНУ-ын геостратегийн сонирхлыг Монголд бэхжүүлэх том зорилтод ерөнхий сайдын амлалт нийцэж ч байж болно. Гол нь ийм шийдвэр гаргахыг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөр ярьсан уу, судалгаа хийж эерэг, сөрөг талыг дэнсэлж үзсэн үү, хоёр хөршийнхөө байр суурийг харгалзсан уу гэх мэт асуулт буй. Манай улсын тухайд ярихад субъектив шийдвэр гаргалт их байдаг нь бас иймэрхүү эргэлзээ төрөхөд хүргэж ч байж болох юм.

Еврази дахь Монголын байр суурийг тодорхойлохдоо манай орон геополитикийн хэд хэдэн бэрхшээлтэйгээ тооцож үзэх нь зүйтэй санагдана. Ийм бэрхшээлд бидний бодлоор дорхи зүйлүүдийг юуны өмнө хамааруулж болмоор. Тухайлбал:

1. Газарзүй, геостратегийн талаасаа "түгжигдмэл орон" (Landlocked, nuclear - locked, Great - Power - Locked);
2. Байршлынхаа буюу эзлэж буй орон зайнхаа хувьд геополитикт эерэг, сөргийн туйл улс ("Country with absolute geopolitical pros and cons") : Азийн буюу Евразийн төвд оршдог атлаа жийрэг (буфер) улсын статустай; газар нутаг томтой боловч хүн ам цөөнтэй, байгалийн ихээхэн баялагтай ч дэлхийн гол гол зах зээлээс алслагдсан;
3. Шашин шүтлэгийн хувьд ерөнхийдөө шарын шашинт гэгдэх боловч үнэн алдартан, лал, күнзийн болон бусад ёсны уулзалт оршдог;
4. Соёл иргэншлийн хувьд суурин ба нүүдлийн соёл иргэншлийн сөргөлдөөн, өрсөлдөөний төв нь болсон;
5. Цаг уурын хувьд ган, зуд ээлжилсэн, говь, хангай нь эрс тэсээрээ ялгарсан, түүнээс болж ард түмний сэтгэл санаа зөрчилдсөн, түүнээс гадна бэлэнчлэх, дагалдах үзэл санаа газар авсан;
6. Хотымсог, хөдөөмсөг зан, ихэмсэг, энгийннийн ялгаа тодорхой мэдрэгдэхүйц болсон;
7. Байгаль, цаг уур, өөрөөр хэлбэл хүрээлэн буй орчныхоо эрс тэс байдлаас болоод хүн ам маань туйлшрах хандлагатай, нэг сонголтоос нөгөө рүү хоромхон зуур эргэдэг, тогтворгүй ааштайгаас геополитикийн ерөнхий чиг шугам нь бусдад ойлгогдохоор бүрэлдэн тогтоогүй;
8. Идеократ систем ард түмний сэтгэл зүрхнээс эцэслэн алга болоогүйгээс төр засгийн дээд удирдлага нь ард түмний санаа бодлыг тэр бүр авдаггүй, харгалздаггүй, иргэд, иргэний байгууллагууд ч шийдвэрийн буруу зөвийг ялгалгүй даган биелүүлдэг, төр засгийн удирдлагын шийдвэр, зааврыг хүлээхээс өөрийн санаачлага гаргах, амьдрах ухаан сийлэх талаараа дутмаг, аялдан дагах, бусдын тусламж дэмжлэгт хэт дулдуйдах сэтгэлгээнд дээр доргүй автагдсан;
9. Ардчилсан буюу далайн сэтгэхүйг тэр бүр ойлгохгүй, хэт задгайрах, дураараа аашлах мэт үздэг, тиймээс ч нэг хэсэг нь хатуу гар - ерөнхийлөгчийн засаглалыг /энэ бол нөгөөх идеократизм / мөрөөдсөн;
10. Шийдвэр гаргалт дээд, доод төвшинд субъектив шинж чанартай,

судалгаа шинжилгээнд нэг их тулгуурлаагүй байдаг нь өнөөгийн ертөнцлөл (Globalization) -д хэрхэн орох, Евразийн өнөөгийн зөрчилт орон зай, их гүрнүүдийн өрсөлдөөнд ямар байр суурьтай, хэрхэн оролцох талаар илэрхий төсөөлөл, үзэл баримтлалгүй байгаагаас харагддаг. Монгол орон жижиг буурай улс боловч том гүрнүүдийн хувьд ач холбогдолтой байршилтайгаа ашиглан эвсэлд үл нэгдсэн, олон тулгуурт, нээлттэй бодлогоо улам идэвхтэй хэрэгжүүлэхийн хамт геополитикийн бэрхшээлүүдээ даван туулах дэс дараатай арга хэмжээ авах, Евразийн баруун өмнөд хэсэг буюу Дундад болон Төв Азийн хямралд татагдан орохгүй, харин тэнд энх амгалан, тогтвортой байдал тогтоох чармайлтад бололцоогоороо тус дөхөм үзүүлэхийг зорих нь зүйтэй. Мөн хөгжлийн алсаа харж Зүүн Хойд Ази руу тэмүүлэн хөгжих нь зүйтэй гэсэн санааг зохиогч удаа дараа илэрхийлж байв. Нөгөөтэйгүүр, Евразид бид өөрийн гэсэн өнгө төрхтэй, өөрөөр хэлбэл, үндэсний эрх ашгаа дээдлэх мэдрэмжтэй, дэлхийн хамтын нийгэмлэгийн анхаарлыг өөртөө татаж өөрийнхөө боломж, нөхцлийг таниулах эрмэлзэлтэй байх ёстой. Үүний тулд жийрэг (буфер) улсынхаа ач холбогдол, статусыг хоёр хөршөөрөө болон бусад түүнх гүрнүүдээр олон улсын эрх зүйн үүднээс хүлээн зөвшөөрүүлж тэдний хувьд геостратегийн болон геополитикийн нэн ач холбогдолтой нутаг дэвсгэр гэдгээ баталгаажуулж халданагүй чухал геополитикийн бүс гэдгээ зөвшөөрүүлэх нь цөмийн зэвсэггүй бүс гэснээсээ ч илүү ач холбогдолтой байж болох юм.

Author made comparative studies of recent theoretical and fundamental research studies of the Russian scholars on EuroAsian Geopolitics. The author highlights the spatial formation of EuroAsian geopolitics, its evolution and historical role and position of Russians and Mongolians who played in it. Description and analysis are made on the North East Asian region as part of EuroAsia and what kind of policy Mongolia should pursue in this crossroad of super powers interests.